

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 1/44

Өлгий

Г

Т

Дархлаажуулалтын дараах урвал,
хүндрэлийн багийг байгуулах тухай


Эрүүл мэнд, спортын сайдын Журамд өөрчлөлт оруулах тухай 2016 оны A/278 дугаар тушаал, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг тандах, сэжигтэй тохиолд ажиллах, дүгнэлт гаргах, хариу арга хэмжээ авах, хяналт тавих мэргэжлийн багийг нэгдүгээр, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журам, гүйцэтгэх үүргийг хоёрдугаар, Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн бүртгэлийн хуудсыг гуравдугаар, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн сарын мэдээний нэгдсэн бүртгэлийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжлийн багийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга /Е.Сауле/, Дархлаажуулалтын их эмч /Т.Ердаулет/ нарт үүрэг даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Ш.Иманхан/-д үүрэг болгосугай.





Эрүүл мэндийн газрын даргын
2023.09.28 сарын 28. ёдрийн 474 тоот
тушаалын үзүүлэлт хавсралт

ЮЕ 0019

Мэргэжлийн багийн бүрэлдэхүүн:

Багийн ахлагч: А.Ерганат ЭМГ-ын ЭТХэлтсийн дарга, хүүхдийн тусlamж хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд: Т.Ердаулет ЭМГ-ын Дархлаажуулалтын их эмч

Т.Нурсауле ЭМГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан
мэргэжилтэн

Д. Гүлжан НЭ-ийн Чанарын албаны дарга

М.Ахбота НЭ-ийн Мэдрэлийн эмч

Б.Бердимурат НЭ-ийн Мэс заслын эмч

М.Амангул НЭ-ийн Лабораторийн эмч



Эрүүл мэндийн газрын даргын
2023.09.28. сарын 28-өдрийн А/44 тоот
тушаалтын зоёлын дугаар хавсралт

БЮЕ0019

Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтний гүйцэтгэх үүрэг

Аймгийн хэмжээнд ДДУХ-ээс сэргийлэх болон ДДУХ бүртгэгдсэн тохиолдолд тандалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн хүлээн авсан ДДУХ-ийн мэдээллийг аймгийн ЭМГ-ын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар болон цахимаар өгнө

ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдээгүй тохиолдолд *0" мэдээг цочмог сул саажилт /ЦСС/ болон тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээний хамт 7 хоног бүр өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, төрөх тасгаас утсаар болон цахимаар хүлээн авсан мэдээллийг Аймгийн Эрүүл мэндийн дархлаажуулалтын албанад утсаар болон цахимаар мэдээлнэ

Энэ журмын 2.5-д заасан мэдээллийг хүлээн авсан дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны ДДУХ аюулгүй дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар болон цахимаар 24 цагийн дотор яаралтай мэдээлнэ ДДУХ-ийн тохиодол бүрт энэхүү тушаалтын хоёрдугаар хавсралтын дагуу судалгаа хийж, нэг хувийг тухайн урвал хундрэл илэрсэн нэгжид. хоёр дах хувийг ХӨСҮТ-д, гурав дах хувийг аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн нэгдлийн архивт хадгалуулна

ДДУХ-ийн тохиолдлын мэдээ авмагц аймаг, дүүргийн, сумын эрүүл мэндийн төвийн дарга нь мэргэжлийн баг (дархлаажуулалт хариуцсан их эмчээр ахлуулсан хүүхдийн зохицуулах мэргэжилтэн, мэдрэлийн эмч, чанарын менежер. нян судлал, клиник лабораторийн эмч, мэс заслын эмч гэх мэт бусад эмчийн бүрэлдэхүүнтэй)- ийг томилон ажиллуулна

Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн тохиолдлын шалтгааныг тогтоох зорилгоор дархлаажуулалттай холбоотой бүх үйл ажиллагааг хянаж нарийвчилсан судалгааг ажлын 3 хоногт багтаан хийж, эхний дүгнэлтийг гарган, харьяа аймаг дүүрэг, аймгийн Мэргэжилийн хяналтын газрын эмчилгээний чанарын хяналтын байцаагчид хүргүүлж ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг магадлан тогтоолгоно Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн сэжигтэй өвчтөнг шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Вакцин, зүү тариурын сорьц, өвчтөнөөс авсан шинжлэгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийлгэж шинжилгээний хариуг албан ёсоор Аймгийн Эрүүл Мэндийн Төвийн

дархлаажуулалтын албанд. Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлнэ. Шинжилгээний зардлыг дархлаажуулалт хийсэн эрүүл мэндийн байгууллага хариуцна

Цаг хугацаа газар зүйн адил байрлалд нэг төрлийн вакцин тариулсан, ижил шинж тэмдэгтэй ДДУХ-ийн сэжигтэй тохиодол байгаа эсэхийг ирлүүлэх идэвхтэй тандалт (хүүхдийн эмнэлэг тасагт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөн өвчний түүх, үзлэгийн журнал, дуудлагын хуудас, хүлээн авахын бүртгэл) -ыг зохион байгуулна.

**Дархлаажуулалт хийдэг эмнэлгийн нярайн болон хүүхдийн
эмч нарын гүйцэтгэх үүрэг**

Хүүхдэд дархлаажуулалт хийх тохиолдол бүрийн өмнө эрүүл мэндийн үзлэг хийнэ Эхийн жирэмслэлт, төрөлтийн явц, удмын байдал, хүүхдийн бие сэтгэцийн өсөлт, өвчилж байсан өвчин, урьд нь вакцин тариулсаны дараа урвал хундрэл илэрч байсан эсэхийг судална Дархлаажуулалт хийхэд эсрэг заалт байгаа эсэхийг тогтоож, харшлах заалт илэрсэн хүүхдэд эмчилгээ хийж эрүүлжүүлж, цаашид ямар вакинаар, ямар товлолоор хийхийг тогтоож өгнө

Мэдрэлийн талаас эмгэгтэй, амьсгалын замын болон бусад өвчнөөр байнга өвчилдөг, урьд нь дархлаажуулсны дараа урвал хундрэл илэрч байсан, өндөг болон ямар нэгэн эмийн зуйл хэрэглэсний дараа харшил илэрч байсан хүүхдийг дархлаажуулах асуудлыг шийдвэрлэнэ

Тухайн хүүхдийг дархлаажуулсан талаар эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, нярайн түүхэнд тэмдэглэл хийнэ Тухайн өдөр хүүхэд ямар вакцины хэддүгээр тун хийлгэхийг бичнэ

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нь ДДУХ буртгэгдээгүй тохиолдолд "0" мэдээг цочмог сул саажилт /ЦСС/ болон тарилгатай хэлдварт өөчний тандалтын мэдээний хамт 7 хоног бүр харьяа аймаг, дүүргийн, дархлаажуулалт хариуцсан маргэжилтэнд утсаар болон цахимаар мэдээлнэ.

ДДУХ-ийн сэжигтэй тохиолдол илэрвэл өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төөийн эмч харьяа аймаг дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд 'Дархлаажуулалтын тухай" 2012 оны 217 дугаар тушаалын гуравдугаар хавсралтад заасан мэдээлэх хуудасны дагуу 24 цагийн дотор утсаар болон цахимаар тус тус мэдээлнэ.

ДДУХ илэрсэн үед яаралтай тусламж үзүүлж. шаардлагатай тохиолдолд эмнэлэп хэвтүүлэн эмчлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна

ДДУХ-ийн тохиолдол бүрийг энэ тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу бүртгэнэ.

ДДУХ илэрсэн тохиолдолд харьяа аймаг. дүүргийн мэргэжлийн хяналтын байцаагчид мэдэгдэж "Дархлаажуулалтын тухай" 2012 оны 217 дугаар тушаалын зургаадугаар хавсралтад заасан зааврын дагуу вакцин, зүү тариураас дээж авч шинжлүүлэн, шинжилгээний хариуг Аймгийн Эрүүл Мэндийн Төвийн дархлаажуулалтын албанд, Халдварт өвчин судлалын үндэсний төвд ирүүлнэ. Шинжилгээний зардлыг дархлаажуулалт хийсэн эрүүл мэндийн байгууллага хариуцна

Дархлаажуулалт хийдэг эмнэлгийн нярайн болон хүүхдийн эмч нь ДДУХ-ийн тохиолдол бурд "Дархлаажуулалтын тухай" 2012 оны 217 дугаар тушаалын дөрөдүгээр хавсралтын дагуу судалгаа хийж нэг хувийг харьяа аймаг. нийслэл, дүүрэг Халдварт өөчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд явуулж, хоёрдахь хувийг байгууллага дээрээ хадгална

ДДУХ-ийн сарын мэдээг энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу бүртгэн, товлолын дархлаажуулалтын хамралтын мэдээтэй хамт харьяа аймаг дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд цаасаар болон цахимаар ирүүлнэ

ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдсэн тухайн сум, орон нутап идэвхтэй тандалт хийж илэрсэн тохиодлын тоог тогтооно.

Дархлаажуулалтын дараа гарч болох урвал, хүндрэлийн талаар эцэг, эхэд мэдлэг олгож. илэрсэн тохиолдолд нэн даруй эмнэлэгт хандах талаар зөвлөлгөө өгнө.



~~ТУЛАС~~...оны ~~о.д.~~...сарын ~~с.в.~~...едрийн ~~и / и/~~...тоот тушаалын ~~лачада~~...хавсралт

Дархлаажуулалтын дараах урвал хүндэрэлийн буртгэлийн хуудас

Засаг захирагааны нэгжийн нэр
20....оны...сарын...өдөр

Дархтура јулашти хијижен

Байгууллагын нэр

2023. оны 09. сарын 28-дөрөнүндө хавсралт

Дархлаажуулалтын дархaa урвал хүндэтгэлийн сарын мэдээний нийтлэгэн бүртгэл

540E0019